

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Булган Ундрага ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 15-р хороо, Махатма Гандигийн гудамж-39, Корпорейт зочид буудлын Эвент Холл-д 10:00 цагаас эхлэв.

Хурлыг нээж хурлын дарга Ч.Ганхуяг хувьцаа эзэмшигчдэд хандан мэнд дэвшүүлж, талархал илэрхийллээ. Хурлын тооллогын комиссоор Блүмсбюри Секьюритис ҮЦК ХХК-ийн Г.Алтансүх, Б.Ариунзул, Б.Баттулга, хурал зохион байгуулж буй комиссын гишүүд болох Булган Ундрага ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Мягмаржав, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга П.Цэнд нарын бүрэлдэхүүн оролцож байгааг танилцуулав. Хурлын дэгийн дагуу тооллогын комиссын дарга Г.Алтансүхийг ирцийг танилцуулахыг урив.

**Танилцуулсан:** Тооллогын комиссын дарга Г.Алтансүх

Хуралд оролцож буй бүх хувьцаа эзэмшигчдэдээ энэ өдрийн мэндийг хүргэе. Булган Ундрага ХК-ийн ээлжит хурлын ирц компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.2 дугаар хэсэг болон 69 дүгээр зүйлийн 69.1 дүгээр хэсгийг тус тус үндэслэн тогтоох нь:

Саналын эрх бүхий энгийн хувьцааны 85,075 ширлэл бөгөөд 75.15%-ийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байна. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 үндэслэн ээлжит хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцсон тухай хурлын дарга Ч.Ганхуягт мэдэгдэж, хурлыг нээв.

**Танилцуулсан:** Хурлын дарга Ч.Ганхуяг

Өнөөдөр бид анх удаагаа Крипто Үндэстэн ХК гэх нэрийн дор хурлаа албан ёсоор эхлүүлэе. Хувьцаа эзэмшигчдэд хурлын дэгийг танилцуулав. Бид компанийнхаа нэрийг Крипто Үндэстэн болгон өөрчилсөн. Хувцааныхаа тикерийг өөрчлөх ажил үлдсэн байна. Та бүхэн ард апаараа саналаа өгөөрэй. Ингээд хэлэлцэх асуудалдаа орьё. Өнөөдөр дараах асуудлуудыг хэлэлцүүлэх болно. Үүнд:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг нөхөн сонгох тухай;
4. Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага өөрчлөх тухай;
5. Бусад асуудал.

Хэлэлцэх асуудлыг батлах уу? Татгалзаж байгаа хүн бий юу?

Татгалзсан хүн байхгүй байгаа тул хурлаа дэгийнхээ дагуу хурлаа явуулж эхлэе. Ийнхүү гүйцэтгэх захирал Г.Мягмаржавыг урьж байна.

**Танилцуулсан:** Булган Ундрага ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Мягмаржав

Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Хөрөнгө Оруулагч Үндэстэн чуулган маань 6 дахь жилдээ зохион байгуулагдаж байна. Бидний компанийн анхны үүсэл хөгжил нь 2017 онд зохион байгуулагдаж байсан Хөрөнгө Оруулагч Үндэстэн чуулганаас үүдэлтэй. Ингээд үндсэн асуудлуудаа хэлэлцье.

**Хэлэлцсэн нь №1:**

Компанийн 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах

**Танилцуулсан:** Булган Ундрага ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Мягмаржав

Манай Крипто Үндэстэн ХК нь криптовалотуудыг судалж, хүмүүсийн оруулсан хөрөнгө оруулалтыг өсгөх үйл ажиллагаа явуулдаг компани юм. Иймд 2021 онд криптовалютын зах зээлд юу болсон тухай танилцуулья гэж бодож байна. 2021 онд криптовалютуудын хувьд их өсөлттэй, дэлхийн нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн жил болж өнгөрлөө. Манай улсын хувьд “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль”-ийг баталснаар бидэнд албан ёсны зөвшөөрөлтэй бирж дээр криптовалотуудыг авч зарах боломж нээгдсэн. Шинээр гарч ирж буй койнууд биржээсээ зөвшөөрөл авч, зах зээл дээр гарч байгаа нь Монгол улсын хувьд нэг том дэвшил болсон гэж харж байна. Криптовалотын зах зээл дээр хамгийн том нь биткойн бөгөөд зах зээлд эзэлдэг хэмжээ нь 70%-иас 40% хүртэл буурсан байна. Энэ нь бусад төрлийн криптовалотууд зах зээл дээр илүү хүчээ авч, зах зээл томорч байгаа гэдгийг харуулж байна. 2021 оны хувьд хүмүүс хувьцаа гэхээс илүү криптовалот руу өндөр хэмжээний хөрөнгө оруулалт хийж байсан нь криптовалютын зах зээл илүү өндөр өсөлттэй байсан гэдгийг харуулж байна. Дэлхийн эдийн засаг тогтворгүй болоход криптовалотууд өндөр хувиар унах боломжтой байсан ч буцаад өсч байгаа нь дэлхий нийт криптовалютыг хүлээн зөвшөөрч байна. Крипто Үндэстэн санг 2017 онд байгуулж, 3 (гурван) тэрбум төгрөг босгож, тал хувиар нь хөрөнгө оруулалт, тал хувиар нь биткойн олборлолт хийж байснаар бид нэлээн их туршлага хуримтлуулсан. Бид хүмүүсээс татсан хөрөнгөндөө нийтдээ 24 BTC биткойн олгож байсан бөгөөд энэ нь өнөөгийн ханшаар 2-3 тэрбум төгрөгийг зөвхөн хувь тэнцүүлэн олгож байсан. Бид өнгөрсөн жил хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн нэрийг Крипто Үндэстэн болгох шийдвэр гаргаж байсан ба энэ нь одоо албан ёсоор улсын бүртгэлийн байгууллагад бүртгэгдсэн байна. Мөн бид 113,212 ширхэг хувьцаатай байсан ба зарласан хувьцааныхаа тоог 1,000,000 ширхэг болгосон нь цаашдаа нэмж хувьцаа гаргах боломжуудыг нээж өгч байна. Монголын хөрөнгийн зах зээлд Крипто Үндэстэн ХК хуучнаар Булган Ундрага ХК нь ямар нөлөөллийг үзүүлж чадсан юм бэ? гэдгийг харахаар бид өнгөрсөн оноос хойш үйл ажиллагаагаа явуулж байгаа боловч бид нар зах зээлийн үнэлгээгээрээ эхний 40 компанид ордог болсон байна. Мөн хувьцааны ханшийн өсөлтөөрөө Монголын Хөрөнгийн Бирж

дээр I-д орсон байсан. Арилжааны идэвх өндөр, хөрвөх чадвартай байна гэдэг нь цаанаа бодит арилжаа явагдаж байгааг илтгэдэг. Манай компани нь арилжааны идэвхээрээ 13 дугаар байранд орсон нь Монголын Хөрөнгийн Бирж дээр томоохон хувьцаануудын нэгт багтаж байна гэж харж байна.

Та бүхэнд хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг бүртгэлийн өдөр болох 2022 оны 4 сарын 8-ны байдлаар танилцуулъя.

№	Нэр	Тоо	Хувь
1	Ард Санхүүгийн Нэгдэл ХК	30,062	28.3%
2	Ард Бит ХХК	20,931	18.5%
3	И Ай Тй ХХК	9,632	8.5%
4	Ард Лайф ХХК	7,810	6.9%
5	С.Оргодол	5,025	4.4%
6	Ч.Ганхуяг	3,081	2.7%
7	Үндэсний Хувьчлалын Сан ХОС	2,500	2.2%
8	Ц.Энх-Амгалан	2,045	1.8%
9	Э.Хасар	2,021	1.8%
10	А.Тулга	2,020	1.8%
11	Бусад 2,446 хувьцаа эзэмшигч	28,085	23.1%

Манай компани 2020 оны 12 сарын 31-ны байдлаар 26 хувьцаа эзэмшигчтэй байсан бол жилийн дараа буюу 2021 оны 12 сарын 31-ны өдрөөр 2,312 хувьцаа эзэмшигчтэй болсон байна. Энэхүү өсөлтөөс харахад компанийг сонирхож буй хүмүүс их байна. 2022 он гарснаас хойш манай хувьцаа эзэмшигчдийн тоо 2,456 болж өссөн. Бид албан ёсоор нэрээ сольж чадаагүй байсан тул олон нийтэд хандсан ажил хийж чадаагүй боловч компанийн хувьцаа эзэмшигчдийн тоо нэмэгдэж байгаа нь эерэг, сайн үзүүлэлт юм.

Хөрөнгө оруулалтын багцын хувьд 15 криптовалютууд байсан бол зах зээлийн уналтаас жижиг криптовалютуудаа зарснаар хамгаалж чадсан. Бид нар криптовалютуудаа зарж, USDT буюу доллар хэлбэрээр хадгалж байгаа ба дэлхий дээр хамгийн сайн өсөх боломжтой криптовалютад хөрөнгө оруулалт хийхээр судалгаа шинжилгээ хийж байна.

Өнгөрсөн онд компанидаа 4,380,000,000 хөрөнгө оруулалтыг хийсэн бөгөөд энэ нь хуучин Кripto Үндэстэн сангаас шилжиж орж ирсэн хөрөнгө юм. 2021 оны жилийн эцэст нийт хөрөнгийн хэмжээ 16.6 тэрбум төгрөг хүртэл өссөн байна.

Үзүүлэлт	2020 -12-31	2021-12-31
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	-	1,014
Дансны авлага	-	576,838
Бусад санхүүгийн хөрөнгө	-	1,000
Урьдчилж төлсөн зардал	-	5,387

Бусад эргэлтийн хөрөнгө	4,578,284	16,029,902
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,578,284</b>	<b>16,614,140</b>
Дансны болон бусад өглөг	-	5,338
Татварын өглөг	-	2,721
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>-</b>	<b>8,059</b>
Хойшлогдсон татварын өр төлбөр	19,824	1,195,783
<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>19,824</b>	<b>1,195,783</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>19,824</b>	<b>1,203,842</b>
Өмч-хувьцаат	19,742	11,321
Нэмж төлөгдсөн капитал	-	8,421
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	178,413	10,762,044
Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	4,380,000	4,380,000
Хуримтлагдсан ашиг алдагдал	-19,694	248,512
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>4,558,461</b>	<b>15,410,299</b>
<b>Нийт өр төлбөр ба эздийн өмч</b>	<b>4,578,284</b>	<b>16,614,140</b>

2021 оны жилийн эцэст жижиг криптовалютуудаа борлуулснаас үүдэн 267 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Үзүүлэлт	2020 -12-31	2021-12-31
Бусад орлого	-	288,620
<b>Нийт орлого</b>		<b>288,620</b>
Борлуулалт, маркетингийн зардал	2,539	9,326
Ерөнхий ба удирдлагын зардал	-	9,280
Санхүүгийн зардал	-	86
Бусад олз (гарз)	48	
<b>Нийт зардал</b>		<b>18,692</b>
<b>Татварын өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>-2,491</b>	<b>269,928</b>
Орлогын татварын зардал	-	2,721
<b>Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал</b>	<b>-2,491</b>	<b>267,206</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	178,413	8,457,174
<b>Нийт дэлгэрэнгүй ашиг</b>	<b>175,921</b>	<b>8,724,380</b>

Манай компанийн аудитыг Хүлэгт Хүннү Аудит ХХК нь хийж гүйцэтгэсэн. Та бүхэн дүгнэлтэй танилцах боломжтой бөгөөд дүгнэлтийн гол санаа нь ОУНББ-ийн стандартыг хангасан буюу эерэг дүгнэлт гарсан байна.

### **Хэлэлцсэн нь №2:**

Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай

**Танилцуулсан:** Булган Ундрага ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Мягмаржав

Бид бүхний дараагийн хэлэлцэх асуудал нь “Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай” байгаа ба та бүхэнд дүгнэлтийг танилцуулья.

### **КРИПТО ҮНДЭСТЭН ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ**

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагч та бүхэнд Крипто Үндэстэн ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг Төлөөлөн Удирдах зөвлөлийн (цаашид “ТУЗ” гэх ) хурлаар хэлэлцэн та бүхэнд танилцуулж байна. Крипто Үндэстэн ХК-ийн ТУЗ нь тайлант онд компанийн удирдах үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, холбогдох хууль тогтоомжийг мөрдөн дараах ажлыг амжилттай хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Компанийн нэрийг Крипто Үндэстэн ХК болгон өөрчилж, шинэчилсэн дүрмийг батлав.
- Компанийн зарласан хувьцааны тоог 1,000,000 ширхэг болгож нэмэгдүүлэв.
- Компанийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөн, хуулийн хүрээнд ажиллаж эхлэв.
- Зах зээл уналтад орохоос өмнө шаардлагатай криптовалютуудыг арилжаалж, хөрөнгийг хамгаалав.
- Хууль эрх зүйн хүрээнд шаардлагатай бүртгэлийг холбогдох байгууллагуудад хийлгэв.
- Нийт хөрөнгийн хэмжээ өмнөх жилийнхтэй харьцуулахад 263%-ийн өсөлт үзүүлсэн байна.

Компани нь 2021 оны жилийн эцэст 16.6 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй, 1.2 тэрбум төгрөгийн өр төлбөр, 15.4 тэрбум төгрөгийн эздийн өмчтэй байна. Хөндлөнгийн аудитыг Хүлэгт Хүннү Аудитын компанийг сонгон ажиллуулсан бөгөөд 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 2022 оны 4 сарын ээлжит ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн баталсан. ТУЗ нь улирал бүр гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд хяналт тавьж, компанийн үйл ажиллагаа явуулж буй салбарт судалгаа шинжилгээ хийж, чиглэл өгч ажилласан. Иймд 2021 онд Булган Ундрага ХК-ийн хувьд ТУЗ, удирдлага нарыг амжилттай ажилласан гэж дүгнэж байна.

### **Хэлэлцсэн нь №3:**

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг нөхөн сонгох тухай

**Танилцуулсан:** Булган Ундрага ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Мягмаржав

Бид бүхэн өнгөрсөн жилийн хувьцаа эзэмшигчдийнхээ хурлаар төлөөлөн удирдах зөвлөлийнхөө гишүүдийг сонгож байсан. Энэ жил ТУЗ-ийн нэг гишүүнд өөрчлөлт орсон. Та бүхний мэдэж байгаачлан Б.Гантиг чөлөөлөгдсөн тул Ард Экс ХХК-ийн үйл ажиллагаа хариуцсан захирал Д.Чадраабал буюу манай Кристо Үндэстэн санг 2017 оноос хойш анхнаас нь авч явж байсан хүн ТУЗ-ийн гишүүнд орж ирж байна. ТУЗ-ийн гишүүдэд орох хүмүүсийг танилцуулъя.

№	Нэрс	
1	Чулуун Ганхуяг	Ердийн гишүүн
2	Батбилэг Золбоо	Ердийн гишүүн
3	Чулуунбаатар Хандаа	Ердийн гишүүн
4	Чулуун Ганзориг	Ердийн гишүүн
5	Давааням Чадраабал	Ердийн гишүүн
6	Ганзориг Мягмаржав	Ердийн гишүүн
7	Энхриймаа Хасар	Хараат бус гишүүн
8	Алтангэрэл Тулга	Хараат бус гишүүн
9	Цэрэнгалсан Энх-Амгалан	Хараат бус гишүүн

Эдгээр хүмүүс нэр дэвшиж байгаа бөгөөд та бүхэн Ард аппаараа саналаа өгөөрэй. Ард аппа ашиглах боломжгүй хүмүүс нь саналын хуудас авч бөглөх боломжтой. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж байгаа хүмүүс өөрсдийгөө товч танилцуулав.

#### **Хэлэлцсэн нь №4:**

Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага өөрчлөх тухай

**Танилцуулсан:** Булган Ундрага ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Мягмаржав

Монгол улсад тусгай зөвшөөрөл авсан хоёр бирж байдаг бөгөөд бид Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй. Хувьцаа эзэмшигчдийн хурлаараа бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагаа өөрчлөх буюу Улаанбаатар Үнэт Цаасны бирж ХК (UBX) рүү шилжих тухай асуудал дэвшүүлсэн. Бид МХБ-ийн гурав дугаар ангилалд бүртгэлтэй явж байгаа бол одоо бүртгүүлэх Улаанбаатар Үнэт Цаасны бирж ХК-ийн хөгжлийн талбар ангилал руу орохоор байна. Яагаад энэ бирж рүү шилжихээр санал оруулж байгаа вэ гэхээр МХБ нь арилжааны цагийн хувьд 10:00-13:00 цаг хүртэл гурван цагийн хугацаанд явдаг. Улаанбаатар Үнэт Цаасны бирж ХК нь уян хатан шийдлийг олон нийтэд санал болгосон. Арилжааны цагийг 9:00-16:00 хүртэл буюу уртасгасан цагаар арилжаанд оролцох, төлбөрийн системийн хувьд харилцагч Т+0 өдөр төлбөрөө авах боломжтой байсан. Мөн бусад маржин арилжаа хийх гэх мэт харилцагчдадаа шинэ боломжуудыг олгож байгаа юм. Бид бүртгэл шилжих хугацааг зургаа дугаар сардаа багтаагаад бүртгүүлнэ гэж эхний ээлжид төлөвлөсөн байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаараа энэхүү асуудлыг шийдвэрлэх юм бол бүртгүүлэх ажлууд хийгдэхээр байна. Хэлэлцэх асуудлуудтай холбоотой асуулт бий юу?

**Асуулт.** Дашбал: Хоёр бирж дээр хосолж явах юм болов уу? Бүх хувьцаагаа Монголын Хөрөнгийн Биржээс Улаанбаатар Үнэт Цаасны бирж ХК-руу шилжүүлэх юм болов уу?

**Хариулт.** Булган Ундрага ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Мягмаржав: Монголын Хөрөнгийн Биржээс бүртгэлээ цуцалж, Улаанбаатар Үнэт Цаасны бирж ХК (UBX)-рүү шилжих юм.

**Асуулт.** Улаанбаатар Үнэт Цаасны бирж ХК (UBX) нь хувьцаа гаргасан байсан. Манай компани анхных нь шахуу бүртгүүлэх юм байна. Тэр тал дээр урамшуулал байгаа юу?

**Хариулт.** Булган Ундрага ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Мягмаржав: Урамшууллын зүйл байхгүй.

**Асуулт.** Гарав: Улаанбаатар Үнэт Цаасны бирж ХК (UBX)-ийн засаглал, ямар хүмүүс удирдаж байгаа вэ? Энэ талаар хариулж өгнө үү.

**Хариулт.** Хурлын дарга Ч.Ганхуяг: Саяхан ТУЗ-ийн гишүүдээ шинэчилсэн.

**Хариулт.** Бизнес хөгжил хариуцсан захирал М.Даваажаргал: UBX биржийн талаар дэлгэрэнгүй танилцуулав. Манай биржид 2015 оноос хойш ажилласан туршлагатай хүмүүс ажиллаж байна.

**Асуулт.** Улаанбаатар Үнэт Цаасны бирж ХК (UBX)-ийн ТУЗ гишүүдээр ямар хүмүүс байдаг вэ? Нэрийг нь сонсоё.

**Хариулт.** Улаанбаатар Үнэт Цаасны бирж ХК (UBX)-ийн зах зээлийн үйл ажиллагаа хариуцсан захирал Б.Баяржаргал: Та бүхэн манай вебсайт руу орж, танилцах боломжтой.

**Асуулт.** Хоёр бирж дээр давхар байрлах боломж байгаа юу?

**Хариулт.** Хурлын дарга Ч.Ганхуяг: Давхар байрлах боломжгүй гэсэн хариу сонссон.

Бизнес хөгжил хариуцсан захирал М.Даваажаргал болон Зах зээлийн үйл ажиллагаа хариуцсан захирал Б.Баяржаргал нар хувьцаа эзэмшигчдэд нэмэлт мэдээллүүдийг өгөв.

Асуулт, хариулт дуусав.

Санал хураалт явуулав.

**Тооллогын комиссын дарга Г.Алтансүх:** Булган Ундрага ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын тогтоол №22/02 санал хураалтын дүнг үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав.

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай санал хураалтад 85,075 ширхэг хувьцаа буюу 75,15 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

- 1.1. Зөвшөөрсөн 77,797 ширхэг буюу 91.44%.
  - 1.2. Татгалзсан 00 ширхэг 0.0%.
  - 1.3. Түдгэлзсэн 00 ширхэг 0.0% байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.
  - 1.4. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай санал хураалтад саналаа өгсөн хувьцаа эзэмшигчдийн 2 саналын хуудас нийт 3 ширхэг саналын эрх бүхий хувьцаа хүчингүй болсон. Санал өгөөгүй болон санал хураалтаас хоцорсон 7,278 ширхэг саналын эрх бүхий хувьцаа байна.
2. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдийг сонгох тухай санал хураалтад 510,450 саналын эрх бүхий 75.15 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн овог нэр	Саналын тоо
1	Чулуун Ганхуяг	78,157
2	Чулуун Ганзориг	77,500
3	Батбилэг Золбоо	77,511
4	Чулуунбаатар Хандаа	77,493
5	Ганзориг Мягмаржав	78,067
6	Давааням Чадраабал	77,984

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдийг сонгох тухай санал хураалтад саналаа өгсөн 4 хувьцаа эзэмшигчдийн нийт 678 ширхэг саналын эрх хүчингүй байна.

3. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг сонгох тухай санал хураалтад 255,225 саналын эрх бүхий буюу 75,15 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

№	ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн овог нэр	Саналын тоо
1	Энхриймаа Хасар	77,360
2	Алтангэрэл Тулга	77,367
3	Цэрэнгалсан Энх-Амгалан	77,360

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг сонгох тухай санал хураалтад саналаа өгсөн 4 хувьцаа эзэмшигчдийн нийт 339 ширхэг саналын эрх хүчингүй байна.

4. Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага өөрчлөх тухай санал хураалтад 85,075 ширхэг хувьцаа буюу 75,15 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:
- 4.1. Зөвшөөрсөн 77,811 ширхэг буюу 91.46%.



4.2. Татгалзсан 01 ширхэг 0.0%.

4.3. Түдгэлзсэн 0 ширхэг 0.0% байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага өөрчлөх тухай санал хураалтад саналаа өгсөн 3 хувьцаа эзэмшигчдийн нийт 13 ширхэг хувьцаа санал хүчингүй болсон. Санал өгөөгүй болон хоцорсон 7,263 ширхэг саналын эрх бүхий хувьцаа байна.

Хурлын дарга Ч.Ганхуяг хурлыг хаан үг хэлэв.

Хурал 11 цаг 25 минутад дуусав.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ГАНХУЯГ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

П.ЦЭНД

